

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 09 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 13 цаг 30 минутад эхэлж, 15 цаг 25 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 1 цаг 55 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тухай \2015 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар\	Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн талаар хэлэлцэх явцад гарсан саналуудыг тусгаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.
2	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн танилцуулга	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн танилцуулга хэлэлцэх явцад гарсан санал: 1.Үндсэн чиглэлийн төслийн 2.1.9 дэх хэсгээс Мөст, Цэцэг, Үенч, Мянгад, Булган-1, Дарви, Манхан сум гэснийг хасах 2.2.1.12 дахь хэсгээс Мөнххайрхан, Зэрэг, Мянгад, Цэцэг сум гэснийг хасах 3.2.2.3 дахь хэсэгт Бий биелгээ гэж нэмж тусгах 4.2.2.5 дахь хэсгээс Туулийн наадам гэснийг хасах 5.2.4.6 дахь хэсгээс Хүүхэд бүрт сар бүр 20000 төгрөг олгох төрийн бодлогыг орон нутагт зохион байгуулж гэснийг хасаж найруулах 6.2.4.7 дахь хэсэгт мэдээллийн сан бий болгох гэж нэмэх 7.3.2.1 дэх хэсгээс Ховд сум гэснийг хасах 8.Онцгой байдлын газарт моторт завь, Булган сумын Онцгой байдлын аврах ангид ковш авахад дэмжлэг үзүүлнэ гэж шинээр нэмэлт заалт оруулах 9.Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар нэмэлт заалт оруулах 10.Дари сумын байшин үзүүрээс дундын овоо хүртэлх 98 км хатуу хучилттай авто замыг барина гэж нэмэлт заалт оруулах 11.Зооноз өвчин судлалын төвд

		<p>оношлогооны дизкамерийн асуудлыг шийдвэрлэх талаар мэргэжлийн байгууллагаас тодруулга авч нэмэл заалт оруулах 12.3.3.9, 3.3.10 дахь заалтыг хасах, 4.2.8 дахь хэсэг давхардсан хасах 13.3.4.3 дахь хэсэгт тооны тодруулга дахин хийж танилцуулах 14.3.2.1 дэх заалтаас Ховд сум гэснийг хасах тус тус саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Очирт үүрэг болгов.</p>
3	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн талаарх танилцуулга</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн талаарх танилцуулгыг санал нэгтэй дэмжиж хугацаанд нь Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт хүргүүлэх 2.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн талаарх танилцуулгыг санал нэгтэй дэмжиж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн мэргэжилтэн Б.Гантөмөрт үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 10 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 13 цаг 30 минутанд эхэлж, 15 цаг 30 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Орон нутгийн төсвийн 2016 оны төсөл, 2017-2018 оны төсвийн төсөөлөл	<p>1.2015 онд Концессын гэрээгээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлуудын хөрөнгийн асуудлыг 2017-2018 оны төсвийн төсөөлөлд тусгах</p> <p>2.УИХ-аас Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль баталсантай холбоотой хөрөнгийг тусгах</p> <p>3.Гудамж, талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, өмнө нь барьсан замуудад усны хаялга, ус зайлуулах сувгийг нэмж хийх хөрөнгө болон цахилгааны төлбөрийн асуудлуудыг төсөвт тусгах</p> <p>4.480 айлын орон сууцны хотхоныг бүрэн барьж дуусгахтай холбоотой асуудлуудыг бүрэн тусгах</p> <p>5.Орон нутгийн өмчид орон сууц худалдан авч ахмад настан, хөдөлмөрийн гавьяатнууд, нарийн мэргэжлийн өндөр ур чадвартай залуу боловсон хүчинд түрээсээр эзэмшүүлэх нөхцөл бүрдүүлэх</p> <p>6.Ховд хотын тохижилт үйлчилгээний ажилчдын хариуцаж буй талбайн хэмжээг норм, нормативт тохируулж тоог нэмэгдүүлэх талаар тусгах</p> <p>7.Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 дугаар байр барих асуудлыг судалж, төрийн байгууллагуудыг нэг дор ажиллуулж, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх боломж бүрдүүлэх, байгууллагуудын ажлын байрны ашиглалтын зардлыг хэмнэх</p> <p>8.Баруун бүсийн спортын цогцолбор /хөл бөмбөгийн талбай бүхий/ байгуулах хөрөнгө оруулалтыг тусгах</p> <p>9.Чандмань, Дуут, Мөнххайрхан сумуудыг автозамын сүлжээнд холбох талаар ТЭЗҮ боловсруулах гэсэн асуудал оруулах</p> <p>10.Мөст сумаас Цэцэг сум хүртэлх 21 км автозам барих</p> <p>11.Телекамерын цахилгааны төлбөрийг Цагдаагийн газрын төсөвт суулгах</p> <p>12.Үенч сум хүртэл 35 Ква-гийн ЦДАШ</p>

		татаж, Алтайн нуруу цаад 3 сумыг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгох саналуудыг тус тус тусгаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт үүрэг болгов.
--	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 11 ДҮГЭЭР ХУРАЛ**

2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 09 цаг 10 минутанд эхэлж, 15 цаг 45 минут хүртэл аймгийн Нутгийн удирдлагын ордоны хуралдааны танхимд болж, нийт 5 цаг 30 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	"Ховд-АЗЗА" ТӨХК, Шим ус ОНӨААУҮГазар, Жаргалант сумын 12 жилийн 1, 2, 6, 7 дугаар сургуулиуд, 12 жилийн Цаст-Алтай цогцолбор сургууль, 12 жилийн Прогресс сургууль, "Ховд эрч хүч" ОНӨААУҮГазар, "Хөгжил" Политехник коллеж, Жаргалант сумын 1, 3, 4, 5, 6, 7, 8, 10, 11 дүгээр цэцэрлэгүүдийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай	Тайлан хэлэлцэх явцад гарсан саналуудыг дэмжиж, үүрэг чиглэл өгөх талаар аймгийн Засаг даргын албан даалгавар гаргахаар шийдвэрлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 12 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 09 цаг 10 минутанд эхэлж, 18 цаг 35 минут хүртэл аймгийн Нутгийн удирдлагын ордоны хуралдааны танхимд болж, нийт 8 цаг 25 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Боловсрол , соёлын газар, Хөгжимт драмын театр, Нийтийн номын сан, Музей, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Зооноз өвчин судлалын төв, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Худалдан авах ажиллагааны алба, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн	Тайлан хэлэлцэх явцад гарсан саналуудыг дэмжиж, үүрэг чиглэл өгөх талаар аймгийн Засаг даргын албан даалгавар гаргахаар шийдвэрлэв.

	хяналтын газар, Стандартчилал хэмжилзүйн хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний алба, Сум дундын ойн анги, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаа, Онцгой байдлын газар, Шүүхийн шинжилгээний алба, 2 дугаар дулааны станцын үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай	
--	---	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР